“ИДЭЭ УНДААНЫ ЖИНХЭНЭ ТОВЧ”-Д БУЙ ХЯТАД ҮСГЭЭР МОНГОЛ ДУУДЛАГААР БИЧСЭН ҮГҮҮДИЙГ СУДЛАХУЙ

Х.Улаан-Од[1], Д.Шагдарсүрэн[2], Б.Гэрэлмаа[1], Л.Наранзаяа[1], Ш.Болд[1,3]
[1]“Ач” АУИС, 2ЭЗШУИС, 3МАУА
E-mail: boldshrv@gmail.com

Abstract

STUDY THE WORDS WRITTEN IN CHINESE CHARACTERS WITH MONGOLIAN PRONUNCIATION IN THE “FUNDAMENTAL PRINCIPLES OF FOOD AND DRINK” BOOK

Ulaan-Od.Kh[1], Shagdarsuren.D[2], Gerelmaa.B[1], Naranzaya.L[1], Bold.Sh[1,3]
[1]“Ach” Medical University,2Mongolian University of Pharmaceutical Sciences,
[3]Mongolian Academy of Sciences
E-mail: boldshrv@gmail.com

Compendium of Materia Medica is an encyclopedic work on traditional Chinese materia medica before the 16th century. It was compiled and written by Li Shizhen (1518-1593), a medical expert of the Ming Dynasty (1368-1644). It took Li 27 years to complete the compendium. The first draft was finished in 1578 when Ming China was at its imperial heyday. The compendium is the most complete and comprehensive medical book ever written in the history of traditional Chinese medicine (TCM). It lists, analyses, and describes all the plants, animals, minerals, and other objects that were believed to have medicinal properties. The compendium in effect epitomizes the pharmaceutical achievements and developments of East Asia before the 16th century. Based on his predecessors’ achievements in pharmacological studies, Li contributed further by supplementing and rectifying many past mistakes and misconceptions as regards the nature of many medicinal substances and causes of various illnesses. The compendium in fact heralds the dawning of modern pharmacological studies [1]. The compendium has been translated, totally or partially, into more than 20 foreign languages, including Japanese, Korean, Latin, French, German, English, Russian, etc. It has been reprinted over 100 times in the past 400 years and is still used by scientists, professionals, and practitioners of the field as a monumental reference work [2].

Khusekhui compiled materials of food and beverage, medications, bread, extract, dough, pharmacopeia used in the palace of Mongolian Khaans since Khubilai’s time and secret recipes of famous doctors into “Fundamental Principles of Food and Drink” with the help of Pu Lan Shi. In 3rd year of Tian Lee, the book was presented to Khaan of the Yuan Dynasty. Khaan ordered official I U Ju to write an introduction to it. This book is considered to be written for a long time from Khubilai’s time to Zayat Khaan. He kept a record of the daily dishes of Mongolian Khaans on the basis of careful observation. Later on, medication and medical herb researcher Lee She Jing wrote in his book Herbal Medication that the Summary of Food and Beverage is about the food and beverage of Khubilai Khaan. Undoubtedly, Mongolian Khaans used mostly Mongolian food and beverage. “Fundamental Principles of Food and Drink” reveals the rich practices of Mongolians on food and beverage as well as other substances necessary for growth, health, and good condition.

In our in-depth study of the book, “Fundamental Principles of Food and Drink”, we collected a total of 29 words of Mongolian origin and updated the point and explanations. These Mongolian words further confirm that the book was written by a Mongolian. The results of research on these words are clarified in this article.

Keywords: materia medica, medical book, pharmacological studies, Khusekhui, Mongolian words

Оршил

Хубилай хаан 1274 оноос Монгол газар тариа тарихыг төрийн бодлого болгож, Юань гүрний үед Монгол орны уур амьсгалд зохицон ургах “монгол амуу”-ны шинэ төрөл бий болгожээ [3]. Үүнийг батлах өмнөх үеийн гол эх сурвалж болох “Монголын нууц товчоо”, “Алтан товч” зэрэг түүхэн сурвалжид Хэрэйдийн Тоорил хаан Мэргэдэд олзлогдон тариа цайруулж, мөн Чингис хаан, ах Отчигин нартаа тариа тариул хэмээн түмэн Зөрчидийг өмч болгосон тухай мэдээ байдаг. Чингис хаан “Их улсыг засах нь болсон идээтэй адил” хэмээн айлджээ [4].


Анагаах ухааны түүхийн урт хугацаанд түүний дотроос идээ, ундаа заслын судлал нэн эртний уламжлалтай бөгөөд тухайн үедээ хөгжлийн тодорхой түвшинд хүрсний зэрэгцээ, Юань Улсын үед Хятадын анагаах ухааны судар номонд, XVI зуунаас эхлэн Төвөд анагаах ухааны гол номонд товч боловч тодорхой дурдагдаж иржээ. Энэ талаар сүүлийн үед Монголын анагаах ухааны түүхийн судалгаа хийсэн зарим судлаачид урьд өмнө судлагдаагүй байсан олон арван сурвалж бичиг, судар ном, эд өлгийн зүйлсийг судлан тогтоож дэлгэрэнгүй байдлаар бичсэн төдийгүй заслын ухааны уг сурвалжид тулгуурлан Монголын анагаах ухааны түүхийг 5000 жилээр урагшлуулан тооцох боллоо. Тухайлбал: Академич Ш.Болд Монголын болон гадаадын археологчдийн олж тогтоосон зарим олдворуудын анагаах ухааны хэрэглээг төвөд, хятад сурвалжуудын баримтуудаар нотлон тогтоосон байна [5].

Монголчуудын халуун, дулааны улиралд иддэг идээ, ундааг П.Карпинийн номонд: “Айраг цагаа элбэг зун цагт хүн л өгч бариагүй буюу ямар нэгэн ан шувуу авлаагүй бол мах тун бага иднэ”, “Тэд махыг тун бага, бусад ард түмэн тэр чинээгээр идэж гэмээ нь өлөн зөмөг байхаар л идэх бөлгөө” [6], Г.Рубрукийн номонд: “Монголчууд зунд нь гүүний сүү буюу айраг хэрэглэх учир өөр төрлийн хоолонд нэг их санаа тавихгүй”, “Тэд зунд нь зөвхөн айраг хийнэ”, “Биднийг Сартахын хүрээнд 4 хоноход тэд жаахан айраг өгснөөс өөрөөр бидний хоол ундны тухайд сэтгэл зовсонгүй” гэж бичсэн байдаг [7]. Энэ мэт Монголчуудын идээ ундааны хэрэглээний талаар товч төдий дурдсан судар ном, сурвалж бичгүүдээс үзэхэд 14 дүгээр зууныг хүртэл Монголын тэжээхүй ухааныг судлах асуудал цогц байдлаар тавигдаж байгаагүй, бас тусгайлсан дорвитой бүтээл гараагүй байжээ. Харин 14 дүгээр зууны 30-аад оны үед Юань улсын хааны ордны дотоод асуудал эрхэлсэн сайд, зоогийн эмч Хүсэхүй нь Юань улсын хаадын хэрэглэж байсан идээ, ундааны зохистой хэрэглээг өөрийн туршлагатай уялдуулан “Идээ ундааны жинхэнэ товч” бүтээлээ туурвиж үлдээсэн байна.

Үр дүн

Судалгаандаа дараах сурвалжуудыг гол материал болгон ашиглав.

Sibu congkan 四部叢刊 буюу “Collectanea of the Four Categories” гэсэн нийт 504 эртний номыг багтаасан цуврал цуглуулгыг (1911-1949) эмхэтгэн хэвлүүлсэн уран бүтээлч, улс төрч хүн. Жан Юаньжи Токио хотын Жин-жиа (静嘉) [8] хэмээх номын сангаас “Идээ ундааны жинхэнэ товч” номын Мин улсын Жинтайн хэвлэл.



“饮膳正要” (Yin Shan Zheng Yao)
Мин Улсын хэвлэл

Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч”-д айраг, эсэг, цэгээний талаар хятад үсгээр монгол дуудлагаар бичиж үлдээсэн нь нэн сонирхолтой бөгөөд аргагүй л нүүдэлчдийн идээ ундааны уламжлалт төрлийг багтаасан сонгодог бүтээл гэдэг нь нотлогдож байна. Жишээлбэл:

- Airaq (Айраг)

Тайлбар:

“Идээ ундааны жинхэнэ товч”-д монгол дуудлагаар “Airaq” гэж бичсэн. Айргийг англиар kumiss гэж нэрлээд нийтэд хэвшсэн. Сонирхолтой нь уг бүтээлд ингэний сүү (хоормог)-г айраг гэж тэмдэглэжээ. Айраг гэдэг үг нь исэглэх, холих найруулах гэсэн утгатай. Гэвч ихэвчлэн гүүний сүүг хөрөнгөлөн исгэсэн ундааг айраг гэдэг. Айрагийг эрт үедээ исэг гэж нэрлэж байсан ба мөн цэгээ гэдэг байжээ. Гүүний айраг бол айрагны хамгийн гол сонгодог төрөл юм. Мөн үүнийг гүүний айраг хэмээн үхэр, тэмээний

айрагнаас ялгаж хэлэх явдал зарим нутагт бий. Айраг нь хэд хэдэн янз боловч гүүний айраг нь угтаа “жинхэнэ” айраг юм.

Архи муу ч гэсэн уснаас дээр

Айраг цэгээ ч гэсэн цайнаас дээр

Эв найргүй бол тус үгүй

Эсэг айраггүй бол найр үгүй

- Caqa’an (Сагаан) буюу цагаа [н]

Тайлбар:

Буцалгасан айраг, тараг хоормог, аарц: цагаа амраах (буцалгасан цагааг тогоотой нь тавьж зөөгшүүлэх), цагаа уух (хоормог, аарц уух)

Цагааг тавьж зөөгшүүлдэг

Цагийг хэмнэж хөгждөг

- Cige’en (Сигээн) буюу цэгээ [н]

Тайлбар:

Гүүний айраг. Лувсанданзан. Алтан товчид: цэгээ уух (айраг уух), айраг цэгээ [хоршоо] (айраг), архи цэгээ [хоршоо] (архи айраг) гэх мэтээр тэмдэглэжээ.

Чийгэрсэн малгай наранд сайн

Цэгээ айраг гэдсэнд сайн гэсэн байдаг.

Судлаач Paul D. Buell and Eugene N. Anderson нар “A Soup for the Qan” бүтээлдээ: “Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч”-д 23 монгол үг, хэллэг байх магадлалтай. Эдгээр үгүүдийг “Идээ ундааны жинхэнэ товч”-д байгаа гадаадын бусад үгүүдтэй нэгэн адил хятадаас галиглан сэргээж болно. Галиг нь ихэнхдээ буруу сонссон, буруу дамжуулсан, эсвэл эх үгээ өөрсдөө буруу ойлгосноос болдог. Авиа зүйн хувьд Хойд Хятадын аялгуунд гадаад үг ялангуяа Түрк, Монгол хэлний олон үгийг илэрхийлж чадахгүй байснаас ...” тухайн үгийг шууд дуудлагаар нь бичиж үлдээжээ” [9] хэмээсэн байна. Бид судлагааны явцад Paul D. Buell and Eugene N. Anderson нарын түүсэн 23 үгэн дээр 1 үг нэмж нийт 24 монгол гаралтай үгийг түүж, оноолт болон тайлбарыг шинэчлэв.

Ургамал болон амьтны тухай монгол үгүүд

1. Аварга - abarqu, “Siberian sturgeon”, Том биетэй, аварга загас, эрүүн дороо байрласан том амтай, маш том махчин загас, монголоор шивэр хилэм гэнэ.
2. Алаг хун - alaq qun, “Immature swan”
3. Чацаргана - cicigina, “Hippophae rhamnoides L.”
4. Сарааны үндэс - ja’uqasu[n], “Lily root”
5. Мөөг - mццg, “Leucocalocybe Mongolica (S. Imai)”
6. Харлаг хун - qaralaq qun (Гангар хун), “Cygnus columbianus”
7. Хилэм - qilam, ”Acipenser sinensis”
8. Шармаг - šaqimur (Манжин), “Rape turnip”
9. Тавилгана - tabilqa, “Spiraea media”
10. Тарвага - tarbaqa[n], ”Marmota Sibirica”
11. Их шар хун - yeke siraqun qun, “Golden-headed swan” “Cygnus cygnus”
12. Хулан - kulan, [Equus hemionus]

Сүү, цагаан идээтэй холбоотой монгол үгүүд

13. Айраг - airaq, “Kumiss”
14. Борви - borbi [n], “Achilles tendon of sheep”
15. Цагаа - caqa’an, “Boiled kumiss”
16. Цэгээ - cige’en, “Fermented milk of mares Kumiss”
17. Засаа - jasa’a, “Ram’s testicle”

18. Жинтэй - jingtei, “Heavy, weighty”
19. Махан - miqan–u “Meat”
20. Хонгор - qongqor, “Beige-colored kumiss or whey”1
21. Тос - tosu[n], “Grease,” “Butter”

Бусад монгол үгүүд

22. Хурим - qurim, “Common ritual meal”
23. Таваг - tabaq “Platter”
24. Тэлир - telir, “Чулуун савны нэр”, Тэлир сэвэг гэвэл мал тэжээхэд зориулсан туйвангаар сүлжиж хийсэн сагс. “Basket for feeding an animal” [10]

Эдгээр үгүүдийг хөрвүүлгийн явцад зүүлтээр тайлбарлан дор дор нь хадаж өгсөн. Тайлбарын жишээ болгож дараах хоёр үгийг авлаа.

Möög – мөөг (цагаан мөөг), англи нэр: Mongolian white mushroom, латин нэр: Leucocalocybe Mongolica (S.Imai). Талын цагаан мөөг нь Салбант малгайт мөөгийн ангид хамаарагддаг. Монгол орны ойт хээр, тал хээрийн бүсэд уул толгодын ар бэл, хаяагаар дугуй хагас болон дугуй хэлбэрийн хар ногоон мөөгөн хүрээнд ургана. Монголын уламжлалт анагаах ухаанд нялхсын халуун, савны халуун, дотор халуун бууруулах, элэгний өвчнийг эмчлэхэд, орчин цагийн анагаах ухааны судалгаагаар цусны даралт бууруулах, хавдрын эсийн өсөлтийг саатуулдаг нь тогтоогдсон. Хүнс, эмийн өндөр ач холбогдолтой, сүүлийн жилүүдэд эрс ховордож устах аюул нүүрлээд байгаа төрөл юм [11].

Qaralaq qun – харалах [г] хун, англи нэр: Whooper Swan, латин нэр: Cygnus cygnus. Өнөөгийн ойлголтоор гангар хун юм. Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст амьдардаг том шувуу юм. Монгол оронд тайга, ойт хээр, тал, говийн бүсийн томоохон гол, нууруудад өндөглөн зусах ба Буйр, Ташгайн таван нуур, Ганга нуур, Улз гол, Ойгон, Увс, Хяргас, Хар, Бөөнцагаан, Тэлмэн, Тэрхийн цагаан нуур, Толбо, Хотон, Хоргон, Дөрөө нуурт гангар хун бүртгэгдсэн. Биеийн урт нь 140-160см, далавчаа дэлгэсэн урт 205-275см ба 8-20кг жинтэй, хошуу нь шар өнгө давамгайлсан хар өнгөтэй байдаг.

Дүгнэлт

Бид “Идээ ундааны жинхэнэ товч” номыг гүнзгийрүүлэн судлах явцдаа нийт 29 монгол гаралтай үгийг түүж, оноолт болон тайлбарыг шинэчлэн хийсэн. Энэ нь уг номыг монгол хүн бичсэн гэдэг нь баримтуудаар улам баталгаажиж байна.

Ном зүй

1. Memory of the world register. Ben Cao Gang Mu (本草纲目, Compendium of Materia Medica) (P.R. China). Ref N° 2010-15
2. International Register. Ben Cao Gang Mu (本草纲目). Library of China Academy of Chinese Medical Sciences. 2011
3. Далай Ч. Монголын түүх (1260-1388), гутгаар дэвтэр, УБ, 1992
4. Лувсанданзан. Алтан товч. УБ, УХГ, 1990
5. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2005, х 17
6. Плано Карпини. Монголчуудын түүх (Орос хэлнээс орчуулсан С.Туяа,С.Цолмон). УБ,1988
7. Гильом де Рубрук. Дорнод этгээдэд зорчсон минь. УБ,1988
8. Sibu congkan 四部叢刊 буюу “Collectanea of the Four Categories” нийт 504 эртний номыг багтаасан цуврал цуглуулrg (1911-1949)

1 Хонгор гэдэг хул өнгийг зааж буй. Тиймээс цагаан идээн дотроос өнгөний бэлгэдлээр шар сүүг хэлсэн байж магад юм. Сүүгээр ууraглаг идээ бэлтгэхэд тунаран ялгарах шаравтар өнгийн шингэнийг шар сүү гэнэ. Үүнийг зарим нутагт шар ус, шарс гэх зэргээр нэрлэх нь ч бий. Ээдэм, аарцыг шүүх үед шар сүү тунарч ялгардаг бөгөөд ээдмийн шар сүү нь зөөлөн, харин аарцных исгэлэн үнэр амттай байдаг.

9. Хүсэхүй. Идээ, ундааны жинхэнэ товч (1330 он). Орчуулж, тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022
10. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, p.90-95
11. A Soup for the Qan. Chinese Dietary Medicine of the Mongol Era as Seen in Hu Sihui's Yinshan Zhengyao. Second Revised and Expanded Edition. Paul D. Buell and Eugene N. Anderson. Leiden, Boston, 2010, p.90-95
12. Хүсэхүй. Идээ, ундааны жинхэнэ товч (1330 он). Орчуулж, тайлбар хийсэн Шаравын Болд. УБ, 2022